

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Өлзий-хутаг	Дугаар	L085
Оршин суугаа аймаг	Хэнтий аймаг	Оршин суугаа сум	Баян-Адарга
Төрсөн газар	Хэнтий аймаг Баян-Адарга сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Асартын хурал, Сайхан модны дуган	Сүм хийдийн дугаар	ХЭБА 093, ХЭБА 094
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Асартын хурал, Сайхан модны дуган

-Танай сумд ямар ямар хүрээ хийд байсан, тэр талаар өөрийн мэдэх зүйлийг ярьж өгнө үү?

Хүмэлийн дуган байсан юм. Баруун талд Биндэр сумын төвийн урд талын толгойн өвөр дээр байсан юм. Нуурын урд талд. Ламын хүрээ нэртэй байсан. Бигэр Номун хааны харъяа хийд байсан юм гэнэ лээ. Номун хааны суудалтай байсан юм гэнэ лээ. Зүүнтэй цагийн хурал хааяа хурдаг байсан, Асартын шүтээн гэж нэртэй хурал байсан. Би 9 настай нэг лам нэр зүүсэн. Хөдөө байсан. Лам дээлтэй хүүхэд байсан. Лам ч биш хар ч биш байсан даа.

-Асартын хурал хэдэн дугантай, хэдэн ламтай ямар хурал байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ганц дугантай. Шүтээн нэртэй л байсан даа. Тарахынхаа алдад үхэр төхөөрч нэг хурал хурж байсан гэдэг юм. Гомбо Махгал шүтээнтэй байсан гэдэг. Нярав нь Бураан Чүлтэм гэдэг хүн их олон жил хийсэн юм гэнэ лээ. 10 гаран жилийн өмнө нас барсан. Бэрээвэнгээс л ирүүлж хурдаг байсан гэсэн. Асартын жас гэж байсан гэсэн.

-Жас нь хэр сан хөрөнгөтэй байсан юм бол доо?

Хөрөнгө нь ч мэдэхгүй ээ. Айхтар их юмгүй байсан байх аа даа.

-Хэр олон ламтай байсан юм бол?

30,40өөд лам цугладаг байсан юм гэнэ лээ.

-Ямар ямар онцлох хуралтай байсан бэ?

Би мэдэхгүй.

-Ямар хүн санаачилж хэдэн онд байгуулсан юм бол?

Хүнийг нь ёстой мэдэхгүй. Богдын үед байсан гэхээр 1911 оны үед байсан л юм шиг байгаа юм. Нэлээн дээр байгуулагдсан шүтээн юм шиг байгаа юм. Харин тэр Сайхан модны дуганыг чинь Өндөр лам гэдэг хүн анх бий болгосон гэдэг. Хүйтэн бүлгийн даяанч лам үүрэгтэй ирж байгуулсан гэдэг. Айхтар хүн байсан гэдэг. Хувилгаан шахуу дөвчин хүн байсан гэсэн.

-сайхан модны дуган хэдэн онд байгуулагдсан юм бол?

Сүүлд 1930-аад оны үед байгуулагдсан байх.

-Хэдэн ламтай байсан бэ?

Байсан лам нар нь одоо дууссан. Хорь арай ч хүрэхгүй ламтай, ганц дугантай байсан. Сайхан модны дуган л гэж байсан юм. Балжийн сайхан мод гэж одоо хувхайрсан мод бий байх. Тэнд л байсан гэсэн.

-Шарын шашны ямар чиглэл нь байсан юм бол?

Шарын шашных байсан гэсэн шүү. Ламын хийдэд бол улааных ч байсан. Шарынх ч байсан.

-Хөмлийн дуганы тухай?

Хөмлийн дуган гэж байсан гэж ярьдаг юм. Тэрүүгээр би очиж ч үзээгүй. Мэдэхгүй. Тэр дээхнэ үед хэдэн буриад лам нар суудаг байсан юм гэнэ лээ. Юуных нь мэдэхгүй. Одоо би 87-той. Нас маань надад дэндүү ахдаад байна. Мэдэх юмгүй болж дээ. Домог ярьдаг ч байсан тэр алга болж. Ийм л мунхарсан өвгөн дөө.

-Хүмлийн дуганы байсан газрыг мэдэх хүн байгаа болов уу?

Мэдэхгүй. Би очиж ч байгаагүй.

-Тэр хавиар айл нутагладаг бол мэдэх магадгүй дээ.

Айл байхгүй. Тэр харуул нутаг. Тэнд гээд хэлж чадахгүй байх.

-Баян-Адарга суманд Асартын дуган, Сайхан модны дуган, Хөмлийн дуган гэдгээс өөр ямар хийд байсан бэ?

Хөмөл харуул гэж байсан. Хөмлийн дуган гэж байсан л гэж дуулсан.

-Хөмөл гэдэг маань голын нэрээр нэрлэгдсэн газар уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баруун хойшоо л байгаа даа. Хөмөлийн нутаг. Хөмөл харуулын нутаг л даа. Түмэнжаргалант овоо гэж энэ зүүн ухаа дээр жаалхан овоо байдаг. Богдын их дагина Дондогдулам хатны мэндэлсэн газар юм гэнэ лээ. Хавтгай газар л нэг овоо байдаг байсан. Одоо байдаг юм уу мэдэхгүй.

Дэлгэрхаан гэдэг нь нэг уул байгаа. Улаан хужир гэдгийн хойд талд догшин уул байдаг юмаа. Их дагины гэгээний мэндэлсэн ч гэдэг, оршуулсан ч гэдэг л юм. Нэлээн хатуу догшин овоо байсан гэдэг.

Сайхан модны дуганыг Цэрэндашаас асуугаад үз. Миний дүү байгаа юм.

Мижидсамдан – Хэнтий аймаг Баян-Адрага багийн засаг дарга. Сумын хийдүүдийн тууриудыг зааж өгсөн.